

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
(Жилийн эцсийн байдлаар)**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2019 оны 54 дүгээр тогтоолд тусгуулж, Мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимтэй хөгжүүлж, бэлчээрийн менежментийг сайжруулах, Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, жижиг, дунд үйлдвэрийг бодлогоор дэмжих зорилтын хүрээнд нийт 21 арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан арга хэмжээний 2020 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89¹ дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон тайлангийн хавсралтыг дөрөвдүгээр хүснэгтийн дагуу боловсруулав. Арга хэмжээний хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтооход дээрх журмын долоодугаар бүлэгт заасныг баримталлаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын нэгтгэн ирүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайлан”-г нягтлан үзэх, зарим арга хэмжээний хэрэгжилт хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж тодруулах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв. Үнэлгээний тайланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хурлаар арга хэмжээ тус бүрээр урьдчилан хэлэлцүүлж, гүйцэтгэлийн тайлагналтыг сайжруулах үүрэг даалгавар өгүүлснээр тайлангийн чанар дээшилж, үнэлгээнд өөрчлөлт оров. Төлөвлөсөн арга хэмжээ бүрээс хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах дүнг урьдчилсан байдлаар тогтоож, үнэлгээ хийх үед гарсан бодит үр дүнгийн түвшинтэй харьцуулж хувиар илэрхийлэн үнэлгээг тодорхойлов.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг
2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ,
үнэлгээний товчоо (арга хэмжээгээр)**

Хүснэгт 1

Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт, хувиар					Дунда ж үнэлгэ
			100	70	40	0	(-)	
- Мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимтэй хөгжүүлж, бэлчээрийн менежментийг сайжруулах	2	21	12	8	1	-	-	85.7

¹ Монгол Улсын Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан <http://new.unelgee.gov.mn/economy/-гнийн> системийг ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолоор баталсан журмын дагуу тохируулгатай хэвээр байв.

- Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, жижиг, дунд үйлдвэрийг бодлогоор дэмжих								
---	--	--	--	--	--	--	--	--

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний гүйцэтгэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 82.86 хувьтай үнэлэгдэв. Үүнд: 12 арга хэмжээ “үр дүнтэй”, 8 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 1 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн ба “үр дүнгүй”, “үнэлэх боломжгүй” арга хэмжээ байхгүй.

Дөрөв. Дүгнэлт

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ХХүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний жилийн эцсийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 82.86 хувьтай үнэлэгдэв.

Үндсэн чиглэлийн төлөвлөгөөний сүүлийн 4 жилийн үнэлгээг харьцуулж хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3

Он	Үнэлгээ, %			
	2017	2018	2019	2020
Арга хэмжээ	18	17	28	21
Үнэлгээ	73.3	88.0	78.6	85.7

2. Доор дурдсан зорилт арга хэмжээний хэрэгжилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай буюу “40” үнэлгээтэй хоёр арга хэмжээ:

3.1. Малын үржил, селекцийн хүртээмж, үр дүнг дээшлүүлж, цөм сүргийн малд үзлэг ангилалтыг зохион байгуулан малын бүртгэл, мэдээллийн санг өргөтгөх. 3.1.3. Малын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх хээлтүүлэгч болон цөм сүргийн малын тоо, 1.5 сая толгой;

Тав. Зөвлөмж

Шалгуур² үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай дээрх хоёр арга хэмжээг байгууллага, бүтцийн нэгжийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг нь хангаж ажиллах, тайлагнахыг Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Малын генетик нөөцийн хэлтэст зөвлөж байна.

² ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан ”Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1.3. “эрчимжүүлэх шаардлагатай” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь /31-59 хүртэл хувь/

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН (жилийн эцсийн байдлаар)

Д/д	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Нэгдсэн дүгнэлт
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО							
1	3.1. Малын үржил, селекцийн хүртээмж, үр дүнг дээшлүүлж, цөм сүргийн үзлэг ангилалтыг зохион байгуулан малын бүртгэл, мэдээллийн санг өргөтгөх.	1. Үзлэг, ангилалд хамрагдах малын тоо, сая толгой			1.5	Улсын төсөв: 430.0 Орон нутгийн төсөв: 101.8 Нийт: 531.8	<p>Үржлийн малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх ажилд шаардагдах 430.0 сая төгрөгийг ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-112 дугаар тушаалаар баталж, аймгуудад хамаарах төсвийг тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, аймгийн ХХААГ-т тус тус шилжүүлэн, арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэл, нэгдсэн арга зүйгээр тэднийг хангаж, ажлын удирдамж хүргүүлсэн.</p> <p>1. Улсын төсвийн хөрөнгөөр хавар, намрын технологид хугацаанд 21 аймгийн 99 сумын баталгаажсан үүлдэр, омгийн үржлийн болон цөм сүргийн 94966 бод, 131550 бог, нийт 226516 толгой малыг хувьсын үзлэг ангилалтад хамруулахаас 94566 бод, 200049 бог, нийт 294615 малыг хамруулж, гүйцэтгэл 130.0 хувьтай байгаа нь өмнөх оны түвшинтэй харьцуулахад 40.7 мянган толгой малаар цөөн байна. Үзлэг ангилалтад хамрагдсан бод малын 31.5% буюу 29813 нь цөм, 52.2% буюу 49678 нь үржлийн, 15.9% буюу 15075 нь хэрэгцээний сүрэг, бог малын 34.7% буюу 69374 нь цөм, 48.1% буюу 96232 нь үржлийн, 17.2% буюу 34443 нь хэрэгцээний сүргийн шаардлага тус тус хангаж, нийт сүрэгт үржлийн мал дийлэнх хувийг эзэлж байна.</p> <p>2. Орон нутгийн төсөв, сум хөгжүүлэх сангийн 101.8 сая төгрөгийн хөрөнгөөр 6 аймгийн хэмжээнд 3101250 хонь, 701854 ямаа, 30431 үхэр, 20561 тэмээ, нийт 3854096 толгой малд шилэн сонголт, ангийн ангилалт хийсэн. Үүнээс нутгийн шилмэл омгийн малд хувьсын ангилалт хийж, үржил селекцийн ажлын ололтыг хянан магадлаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулав. Үүнд: БаХ, Бу, ӨмГ, ДуГ аймгийн 269315 хонь, ӨмГ, Хэ аймгийн 56100 ямаа, Төв аймгийн 23000 үхэр, ДуГ аймгийн 7000 тэмээ, нийт 355415 толгой малыг цөм сүрэгт бүрдүүлэв.</p> <p>Хавсралт : 4 файл</p> <p>Хүрсэн түвшин : Улсын хэмжээнд 2020 онд давхардсан тоогоор 4.5 сая толгой малыг ангийн болон хувьсын үзлэг, ангилалтад хамруулж, анги чанарыг тогтоов.</p>

2		2. Малын үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний нэгжийн тооны өсөлт, хувиар			30	Орон нутгийн төсөв: 216.0 Төсөл хөтөлбөр: 108.5 Нийт: 324.5	<p>Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийг шинээр байгуулах, үүсгэл санаачилгыг дэмжих чиглэлийг бүх шатны мэргэжлийн байгууллагад хүргүүлснээр 2020 онд шинээр 35 нэгж байгуулагдаж, нийт 151 нэгж үйл ажиллагаа явуулж байна. Улсын төсвийн 430.0 сая₮-ийн хөрөнгөөр малын үзлэг ангилалтын ажлыг 59 нэгжтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлэв. ХААХОУС-ийн зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил Нэмэлт санхүүжилт төсөл хэрэгжиж буй АрХ, ӨвХ, ДуГ, До, Сү, Хэ аймгийн 13 суманд 108.5 сая₮, орон нутгийн оролцооны 216.0 сая₮-ийн зоо багаж, тоног төхөөрөмжийг мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжид дэмжлэг болгон олгов.</p> <p>-Мал үржүүлэг технологийн ажил эхлэхтэй холбогдуулан 4.17 нд 21 аймаг, нийслэлийн мал үржүүлэг технологийн эгжийн төлөөлөл 18 мал зүйчдэд цахим сургалтыг явуулж арга зүйн зөвлөмжөөр хангав.</p> <p>-Ар аймагт 9.24-25нд “Эрүүл бэлчээр-Эрүүл мал-Эрүүл хүнс” зөвлөгөөн зохион байгуулж, оролцсон нэгжийн 115 мэргэжилтэнд “Таван төрлийн малын үржлийн ажлын төлөвлөл”, “Малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхэд анхаарах нь” 4 цагийн танхимын сургалт, 1 өдрийн үзүүлэх сургалт хийв.</p> <p>-Өв аймгийн 19 сумын ХАА-н тасгийн мэргэжилтэн болон 8 нэгжийн 12 мэргэжилтэн, нийт 80 хүнийг хамруулсан сургалт зохион байгуулж, гарын авлага, материалаар хангав. ХААИС-ийн МААБС-тай хамтран “Бод, бог малын ангилагч шинжээч бэлтгэх” танхим болон дадлагын сургалтыг зохион байгуулж, нэгжийн 12 мэргэжилтэнд мал ангилагч шинжээчийн мэргэжлийн үнэмлэх олгов.</p> <p>-За аймгийн төвд 9.23-24нд зохион байгуулсан МАА-н үйлдвэрлэлийн “Асуудал & Шийдэл” сэдэвт хэлэлцүүлэг, зөвлөгөөн “Таван эрдэнэ” фестиваль, үзүүлэх сургалтад оролцсон 24 сумын ХАА-н тасгийн мэргэжилтнүүд, Төрийн өмчит цөм сүргийн аж ахуй, нэгжийн мэргэжилтнүүдэд 4 цагийн мэргэшүүлэх сургалтыг тусгай хөтөлбөрөөр зохион байгуулав. -ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-386 дугаар тушаалаар 11 мал зүйчид "Зөвлөх мал зүйч", 3 мал зүйчид "Тэргүүлэх мал зүйч" мэргэжлийн зэрэг олгов.</p> <p>Хүрсэн түвшин: 2020 онд шинээр 35 нэгж байгуулагдаж, өмнөх оны түвшингээс 30 хувиар нэмэгдэв. Мал зүйч мэргэжилтнийг мэргэшүүлэх, чадавхижуулах 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 95 нэгжийн 115 мэргэжилтнийг хамруулсан.</p> <p>Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Мал үржүүлэг, технологийн ажлыг орон нутгийн нэгжээр гүйцэтгүүлэх, нэгжийг багаж тоног төхөөрөмжөөр хангах ажлыг дэмжин хэрэгжүүлж байна.</p>
---	--	--	--	--	----	---	---

3		3. Малын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх хээлтүүлэгч болон цөм сүргийн малын тоо, сая толгой			1.5	Улсын төсөв: 146.6	<p>Дэлхийн худалдааны байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол улсын малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх системийг шинэчлэх” /STDF/PG/534/ туршилтын төслийн хүрээнд төсөл хэрэгжиж буй Өвөрхангай аймгийн Баянгол, Гучин-Ус, Бат-Өлзий, Уянга сумын нийт 190.0 мянган малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүл-эхээс 91.2 хувь буюу 173.2 мянган толгой малыг бүртгэлжүүлж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг оруулав. Монгол адууны үүлдэрлэг байдалд молекул биологийн судалгаа хийх, стандартыг шинэчлэн тогтоох, хурдан морины цахим бүртгэлийн программ, мэдээллийн сан бий болгох ажлыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, 1200 адуунд туршилтын чип суулгах, цус авах ажлыг гүйцэтгэв. Манай улсад баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийж, ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, технологид хугацаанд 12.9 мянган малчин өрхийн 335.3 мянган толгой цөм сүргийн мал, Өв аймгийн төслийн сумдын 173.2 мянган толгой малыг 2020 онд шинээр ялган тэмдэглэж, 1046.7 мянган толгой үржлийн, нийт 1555.2 мянган толгой малын мэдээллийг Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд /оффлайн, онлайн/ оруулж, жилийн эцсийн байдлаар тус санд 4.5 сая толгой малын мэдээлэл бүртгэлтэй байна. Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд шинээр бүртгэгдсэн 1.5 сая толгой малын 17.4 мянга буюу 1.1 хувь нь үржлийн хээлтүүлэгч, 508.5 мянга буюу 32.7 хувь нь цөм сүргийн мал байна.</p> <p>Хүрсэн түвшин: Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд нийт 525.9 мянган толгой үржлийн хээлтүүлэгч болон цөм сүргийн малын мэдээллийг/оффлайн, онлайн/ оруулж, жилийн эцсийн байдлаар тус санд нийт 4.5 сая толгой малын мэдээлэл бүртгэлтэй байна.</p>
4	3.2. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх.	1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо, сая толгой /давхардсан тоогоор/			59	Улсын төсөв 22,3 тэрбум, орон нутгийн төсөв 6,4 тэрбум төгрөг.	<p>2020 онд мал, амьтны гоц халдварт 3 нэрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад нийт 32,1 сая толгой мал, халдварт 19 нэрийн өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор 39.2 сая толгой мал, амьтан, нийт 22 нэрийн өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 71.3 сая толгой мал, амьтан хамруулсан. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт бүртгэгдээгүй тайван байлаа. Гоц халдвартын тарилгын үйлчилгээний хөлсөнд давхардсан тоогоор 951 МЭҮН-д 4,9 тэрбум төгрөг олгосон.</p> <p>2020 оны жилийн эцсийн мэдээгээр Монгол улсын хэмжээнд мал, амьтны 21 нэрийн халдварт өвчин бүртгэгдэж, давхардсан тоогоор 776 суманд 1163 удаагийн гаралтаар 8950 мал, амьтан өвчилж, үүнээс 2548 мал, амьтан хорогдож, 394 мал, амьтныг зориудаар устгаж, 15 мал, амьтныг нядалсан бол 5993 толгой мал, амьтан эдгэрсэн байна. 2019 онтой харьцуулахад халдварт өвчний гаралтын тоо 58, өвчилсөн малын тоо 8687 толгой, үхсэн малын тоо 1654 толгойгоор тус тус буурсан байна.</p>

						Халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын үйлчилгээний хөлсөнд МЭҮН-үүдэд улсын төсвөөс 3,6 тэрбум, орон нутгийн төсвөөс 2,1 тэрбум төгрөг олгосон. Хүрсэн түвшин : 2020 онд гоц халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй бол халдварт өвчний гаралт 5.0 орчим хувиар буурсан. Бүртгэгдсэн мал, амьтны 21 нэрийн халдварт өвчнөөс 9 нэрийн халдварт өвчин вакцингүй, 12 нэрийн халдварт өвчин дархлаажуулалттай байна.	
5		2. Вакцинжуулалтын дараах тандалт шинжилгээнд хамруулах малын тоо, мянга			200	220,000,000	Шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг зэрэг мал, амьтны гоц халдварт өвчнөөс сэргийлэх тарилгын төлөвлөгөө, гүйцэтгэлийг мал эмнэлгийн цахим системээр дамжуулан улсын хэмжээнд хянаж, хяналт, шалгалт хийсний дараа тарилгын үйчилгээний хөлсийг олгосон. Тус цахим системээр дамжуулан нийт 26,0 сая толгой малыг урьдчилан сэргийлэх тарилгад хамруулсан хяналтыг хийсэн. 2020 онд Бруцеллёзын вакцинжуулалтын дараах мониторингийн лабораторийн шинжилгээнд нийт 9,280 толгой мал хамруулсанаас 7,866 сорьц эерэг урвал үзүүлж, дархлаажилтын үр дүн 84,7 хувь, шүлхий өвчний вакцинжуулалтын дараах мониторингийн лабораторийн шинжилгээнд нийт 4,950 толгой мал хамруулсанаас О хэвшилд 3,833 сорьц, А хэвшилд 3,967 сорьц эерэг урвал үзүүлж, дархлаажилтын үр дүн О-77.4, А-80.1 хувь, Бог малын мялзан өвчний вакцины дараах мониторингийн лабораторийн шинжилгээнд нийт 4,992 толгой мал хамруулсанаас 2,988 сорьц эерэг урвал үзүүлж, дархлаажилтын үр дүн 60 хувьтай тус тус байв. Тус 3 өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад хамруулсан малын лабораторийн сорьцын тоо 19222, дархлаажилт дунджаар 75.55 хувьтай гарсан. Мөн мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын гүйцэтгэлийн мониторингийг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газраас малчны өрхийн дэвтрийн бичилтийг шалгах, эзнээс утсаар асуух, аман асуулга авах, тарилгын явцад дагаж хяналт тавих хэлбэрээр зохион байгуулсан. Тус хяналтаар аймаг бүрт 2-3 сум хамруулж, сум тус бүрт 5-10 өрхөд хяналт хийсэн бөгөөд дунджаар нэг өрхийн 450 толгой мал хамрагдсанаар улсын хэмжээнд нийт 280,0 мянга гаруй малыг дархлаажуулалтын дараах мониторингийн тандалт шинжилгээнд хамруулсан. Ингэснээр 2020 онд улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт, халдварт 22 нэрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулсан нийт 71,3 толгой малын 36,9 хувийг вакцинжуулалтын дараах тандалт шинжилгээнд хамруулж, вакцинжуулалтын гүйцэтгэл сайн хийгдсэн гэж үзсэн байна. Хүрсэн түвшин : 2020 онд улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт, халдварт 22 нэрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулсан нийт 71,3 толгой малын 36,8 хувийг вакцинжуулалтын дараах тандалт, шинжилгээнд хамруулснаар вакцинжуулалтын гүйцэтгэл сайн хийгдсэн гэж үзсэн байна.

6	3.3. “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.	1. Хэрэгжилтийн явц, хувиар			30	Улсын төсөв: 319.6 Орон нутаг: 500.0 Нийт: 819.6	ЗГ-ын 2018 оны 400 дугаар тогтоолоор тус хөтөлбөр батлагдсан. Хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 120 дугаар тушаалаар батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тариалангийн бүс нутагт эрчимжсэн МАА, газар тариаланг дэмжин хөгжүүлэх, төрөлжүүлэх зорилгоор 9 Сард Да, Сэ аймгийн малчид болон тариаланчидтай уулзалт зохион байгуулж, нөхцөл байдлыг судалсан. 2020.09.30-ны өдрийн ЗГ-ын 130 дугаар тогтоолоор сүүний урамшуулал олгох журмыг баталсан. Сүүний үйлдвэрт нийлүүлсэн сүүгээ и-баримтад бүртгүүлэн баталгаажуулсан 2375 малчин, эрчимжсэн МАА эрхлэгчдэд ХХААХҮ-ийн сайдын А-387 дугаар тушаалын дагуу 969,972,000 төг-ийн мөнгөн урамшуулал олгов. Мөн сайдын тушаалаар эрчимжсэн МАА-н хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгуудын ХХАА-н газар тус бүрт 10-25 сая, нийт 319.6 сая төг-ийн санхүүжилт хуваарилан хүргүүлсэн. МУ-ын ЗГ, Беларусь улсын ЗГ хоорондын урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр сүүний чиглэлийн 3000 үнээ бүхий 5 Фермийг газар тариалан бүхий бүс нутагт байгуулах хэлэлцээр хийгдсэн. 2020 онд төсөл сонгон шалгаруулалт зарлаж Сэ, Да, Төв аймгийн 5 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, ферм барих газарт нь геодезийн шинжилгээ хийлгэсэн. Одоогоор фермийн барилга барих нэгжийн сонгон шалгаруулалт явагдаж байна. 2020 оны 11 сард "Нүүдэлчин" ХХК Франц улсаас өөрийн хөрөнгөөр 96 монбильярд үүлдрийн гунжийг импортлон кластер фермээ өргөтгөв. Да аймаг орон нутгийн төсөвт 500 сая төг тусгаж, 150 толгой сүүний чиглэлийн симменталь үүлдрийн үхрийн ферм байгуулав. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, ХХААХҮ-ийн сайдын хамтарсан тушаалаар зөгийн аж ахуйд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг батлуулан хэрэгжүүлж байна. Эрчимжсэн МАА-н хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрт тусгагдсан хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт 2019 оны жилийн эцсийн хэрэгжилт 78.57 хувь, үр дүнгийн үзүүлэлтийн дундаж 78.84 хувьтай байсан ба 2020 оны хэрэгжилтийн явц урьдчилсан байдлаар 70.0 хувь үнэлэгдэв. Хүрсэн түвшин : Хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтийн явц урьдчилсан байдлаар 70 хувьтай байна.
7	3.4. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын эрх зүй, хариуцлагын тогтолцоо, бэлчээрийн менежментийг сайжруулах.	1. Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулсан аймгийн тооны өсөлт, хувиар			50	Төсөл хөтөлбөр: 142.0	1. Швецарийн хөгжлийн агентлагийн “Ногоон алт малын эрүүл мэнд” төслийн 95.3 сая₮-өөр 21 аймгийн ХХААГ, 330 сумын ХАА-н тасгийн мэргэжилтэнийг оролцуулан 570 гаруй хүнд “Бэлчээрийн ашиглалтыг сайжруулах нь” зөвлөгөөн Ар, До, ДуГ, Хо аймагт зохион байгуулж, бэлчээрийн харилцааг зохицуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах, төлбөр авах боломжийн талаар мэдээлсэн. Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийн дагуу бэлчээр ашигласны төлбөрийг бэлчээрийн төлөв байдал, бэлчээрийн даац хэтрэл, малын тоо, малын төрлийн харьцааг харгалзан ялгавартай

						<p>тогтоож авах, төлбөрийг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж тухайн сумын МАА-н үйлдвэрлэл, бэлчээрийн менежментэд зарцуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулав. УИХ-ын 2020.11.13 өдөр “Малын тоо толгойн албан татварын тухай хууль”-ийг хэлэлцэн, баталж 2021.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхлээд байна.</p> <p>2. “Ногоон алт малын эрүүл мэнд” төслийн 46.7 сая₮-ийн санхүүжилтээр 8 аймагт орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийн судалгаа хийснээр Ар 178.0 мян га, ДуГ 205,6 мян га, До 299.9 мян га, ӨвХ 496.5 мян га, ӨмГ 3030.0 мян га, СүБ 629.8 мян га, Хө 245.6 мян га, Хо 102.3 мян га нийт 5187.7 мян га бэлчээрийг орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээр болгож, хил заагийг газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд оруулах ажлыг аймгуудын Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар хийж байна.</p> <p>3. “Ногоон алт малын эрүүл мэнд” төсөл хэрэгжиж буй 18 аймгийн 1520 бэлчээр ашиглагчдын хэсгийн малчидтай хамтран 2820 цэгт бэлчээрийн төлөв байдлын фото мониторингийн судалгааг хийв. Бэлчээр ашиглалт сургалтыг 5 аймгийн 8 суманд зохион байгуулж сумын ЗД-тай бэлчээр ашиглалтын 63 гэрээ байгуулсан. “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт” төсөл хэрэгжиж буй 6 аймгийн 18 суманд 50 малчдын бүлэг бэлчээрийн даацад малын тоог тохируулах, талхлагдсан бэлчээрийг зохистой ашиглан сайжруулж, нийт 120.0 мян га бэлчээрийг сэлгэн өнжөөж сайжруулав. Хүрсэн түвшин : Бэлчээрийн ашиглалтыг хариуцлагажуулах арга хэмжээнд МАА-н чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр нилээд ажлуудыг гүйцэтгэсний үр дүнд 18 аймагт бэлчээрийн ашиглалт, хамгаалалт тодорхой хэмжээгээр сайжирч, өмнөх оны түвшингөөс 60%-иар нэмэгдсэн байна. УИХ-ын 2020.11.13-ны өдөр Малын тоо толгойн албан татварын тухай хууль батлагдан 2021.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.</p>
8		2. Бэлчээрийн менежментэд зарцуулсан хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх хувь		30	<p>Улсын төсөв: 1670.0 Орон нутгийн төсөв: 3700.0 Гадаадын төсөл хөтөлбөрийн санхүүжилт: 3700.0 Нийт 9070.0</p>	<p>Бэлчээрийн менежментэд 2019 онд улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 57, гадаадын төсөл, хөтөлбөрийн 1.2 тэрбум төгрөгөөр 60, орон нутгийн төсвийн 4.1 тэрбум төгрөгөөр 297 инженерийн хийцтэй худаг, малчдын өөрсдийн санаачлаг-аар 219 гар худаг, нийт 6.5 тэрбум төгрөгөөр 414 инженерийн хийцтэй худаг гаргасан нь 840.0 мянган га бэлчээр буюу 2.2 мянган малчин өрхийн 1.5 сая толгой малын усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ болсон. 2020 онд Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 21 аймгийн 193 сумдад улсын төсвийн 1.67 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 83, гадаадын төсөл, хөтөлбөрийн 3.7 тэрбум төгрөгөөр 180, орон нутгийн төсвийн 3.7 тэрбум төгрөгөөр 287 инженерийн хийцтэй худаг, малчдын өөрсдийн санаачилгаар 170 гар худаг, нийт 9.0 тэрбум төгрөгөөр 550 инженерийн хийцтэй худаг гаргасан нь 825.0 мянган га бэлчээр, 2.7 мянган малчин өрхийн 1.5 сая толгой малын усан</p>

						<p>хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ болсон. 2020 онд бэлчээрийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хэмжээг өмнөх оны түвшинтэй харьцуулахад төсвийн хөрөнгө оруулалт 470 сая төгрөгөөр, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалт 2.5 тэрбум төгрөг буюу 38.5 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Харин орон нутаг болон малчдын санаачилгаар гаргах хөрөнгө оруулалт 400 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. НҮБ-ын ХХААБ, Хөдөө аж ахуйг дэмжих олон улсын сан, Швейцарийн хөгжлийн агентлаг, Мерси кор Монгол зэрэг байгууллагуудын хүрээнд байгуулагдсан нийт 18 аймгийн 165 сумын 1630 малчдын бүлэг /бэлчээр ашиглагчдын хэсэг/ бэлчээр ашиглах гэрээг сумын Засаг даргатай байгуулан бэлчээрээ хамгаалан ажиллаж байна. Эдгээрээс бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд бүртгүүлэн баталгаажуулсан нь 900 гаруй байна.</p> <p>Хүрсэн түвшин : 2020 онд бэлчээрийн менежментийг сайжруулах арга хэмжээг өмнөх оны түвшинтэй харьцуулахад төсвийн хөрөнгө оруулалт 470 сая төгрөгөөр, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалт 2.5 тэрбум төгрөг буюу 38.5 хувиар тус тус нэмэгдүүлсэн байна.</p>
9		3. Тэмцсэн бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж байгаа үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх арга хэмжээ, талбайн хэмжээ, сая.га		1	Улсын төсөв: 5000.0 Орон нутгийн төсөв: 1200.0 Нийт 6200.0	<p>Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Мэрэгч судлалын болон Шавж судлалын лабораторийн эрдэм шинжилгээний ажилчид хөнөөлт мэрэгч амьтад, шавжын тархалт, олшрохын тодотгох судалгааг 2020 онд 20 аймгийн 215 сумын нутагт гүйцэтгэж, нийт 9.43 сая га бэлчээрийн талбайд ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн.</p> <p>1.Дээрх дүгнэлтэд суурилан бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг энэ оны 4-8 дугаар сарын хооронд улсын төсвийн 5.0 тэр бум төгрөгийн хөрөнгөөр 20 аймгийн 204 сумын нийт 1.65 сая га, 4 аймаг дундын отрын бүс нутгийн 0.64 сая га, нийт 2.29 сая га бэлчээрийн талбайг хамруулан гүйцэтгэлээ. Үүнээс үлийн цагаан оготной тэмцэх ажлыг нийт 1.63 сая га, царцаатай тэмцэх ажлыг 0.66 сая га бэлчээрийн талбайд тус тус хэрэгжүүлсэн нь эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан нийт тэмцэх шаардлагатай талбайн 24.28 хувьд бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх ажил зохион байгуулсан. Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээний 2020 оны гүйцэтгэл нь өмнөх оноос 0.6 сая га, сүүлийн 10 жилийн дунджаас 1.0 сая га талбайгаар тус тус нэмэгдсэнээрээ онцлог байна. Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг 2019 онд өргөн хүрээтэй бүх нийтийн ажил болгон зохион байгуулах зорилгоор Засгийн газрын 185 дугаар тогтоолоор жил бүрийн 5 сарын эхний долоо хоног болон 10 сарын сүүлийн 7 хоногийн Баасан, Бямба, Ням гарагийг “Бэлчээр хамгаалах өдөр” болгон зарласантай холбогдуулан бэлчээр хамгааллын арга хэмжээг</p>

						<p>эрчимжүүлэн өргөн хүрээтэй зохион байгуулж үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээнд 20 аймгийн 200 гаруй сумын 400 гаруй багийн нийт 7000 орчим малчид, иргэд идэвхтэй оролцож ажилласан.</p> <p>2.Орон нутгийн 1.2 тэр бум төгрөгийн хөрөнгөөр микро биологийн бэлдмэлийг 8 аймгийн зарим сумдын 285.0 мянган га талбайд цацаж, бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлж, бэлчээрийн даацыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн болно.</p> <p>Хүрсэн түвшин : Бэлчээрийн ургамал хамгааллын 2020 оны арга хэмжээний үр дүнд нийт 2.29 сая га бэлчээрийн талбайд мэрэгч үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх ажлыг гүйцэтгэж, 43.5 мянган тн өвс буюу 10.8 тэрбум төгрөгийн үнэ бүхий бэлчээрийн ургамлыг үлийн цагаан оготно, царцааны хөнөөлөөс хамгаалж мал аж ахуйн үйлдвэрлэлд ашиглах боломжийг бүрдүүлсэн.</p>
10	4.1. “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах.	1. Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар		40	-	<p>Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоолоор "Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан. "Эрүүл хүнс - Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2020 оны хэрэгжилтийг гаргаж хавсаргав. Хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн томоохон ажлуудаас дурдвал: Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 130 дугаар тогтоолоор батлуулсан. Энэ журмын хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 2375 малчин, фермерийн аж ахуй эрхлэгчдэд ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-387 дугаар тушаалаар нийт 969.9 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. Улсын хэмжээнд 2020 онд 18.6 мянган га талбайд төмс, 9.6 мянган га талбайд хүнсний ногоо, 61.1 мянган га талбайд тосны ургамал, 52.7 мянган га талбайд тэжээлийн ургамал тариалсан. Ковид-19 халдварт цар тахлын эрсдэлтэй нөхцөлд ургамлын гаралтай хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангах зорилгоор хүнсний ногоог өнгөрсөн жилтэй харьцуулахад 26.5 хувиар илүү тариалсан. Улсын хэмжээнд 2020 онд нийт 238.7 мянган тн төмс, 109.2 мянган тн хүнсний ногоо, 160.0 мянган тн тэжээлийн ургамал, 20.2 мянган тн тосны ургамал тус тус хураан авсан. ХХААХҮЯ-наас “Өглөөний цай” болон “Ээжийн сонголт – Эрүүл хүнс” хөдөлгөөний хэлэлцүүлгийг 2020 оны 1 дүгээр сарын 10-нд Төрийн ордонд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан, Дэд сайд Ж.Сауле, ЭМ-ийн сайд Д.Сарангэрэл тэргүүтэй холбогдох төрийн байгууллага болон цэцэрлэг, дунд сургуулиудын удирдлага, багш, эцэг эх, мэргэжлийн тогооч нарын төлөөлөл 100 гаруй хүн оролцсон. Хэлэлцүүлгээс олон нийтэд хандсан уриалга гаргасан. Пестицидийн үлдэгдлийг хянах төлөвлөгөөний төслийг боловсруулж, цахим</p>

						хэлэлцүүлгийг 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулсан. Хавсралт : 1 файл Хүрсэн түвшин : Үндэсний хөтөлбөрийг Засгийн газраас 2019 онд баталсан, 2023 он хүртэл хэрэгжүүлэхээр тусгасан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2020 оны арга хэмжээний дундаж 75 хувьтай байна.
11		2. Нөөцийн махны хэмжээ, мянган.тонн			10	3770,0 Бэлтгэж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах ажлыг 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлүүлсэн. Нөөцийн махыг Нийслэлийн 9 дүүргийн 169 хорооны хүнсний 413 дэлгүүрээр дамжуулан хонины ястай мах 6700 төг/кг, үхрийн ястай мах 7700 төг/кг, ямааны мах 6200 төг/кг үнээр худалдаанд гаргасан. Нөөцийн махны худалдааг 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдөр хүртэл нийслэлийн хүн амд худалдаалж, нийт 10.5 мянган тн махыг нийлүүлээд байна. Нийслэлийн хүн амын 2020 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд доор дурдсан байдлаар махны нөөцийг бүрдүүлсэн. Үүнд: 1. Арижааны банкны эх үүсвэрээр: 12 аж ахуйн нэгж, нийт 8857,0 тн, Үүнээс: үхрийн ястай мах 2025 тн, хонины ястай мах 4968 тн, ямааны ястай мах 1864 тн 2. Өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр: 4 аж ахуйн нэгж, нийт 552,0 тн, Үүнээс: үхрийн ястай мах 305,3 тн, хонины ястай мах 194,0 тн, ямааны ястай мах 52,6 тн 3. Бодлогын гэрээгээр мал, мах бэлтгэсэн: 22 аж ахуйн нэгж, нийт 1102 тн, Үүнээс: сүлжээ дэлгүүрээр 623,14 тн, хүнсний дэлгүүрээр 479.26 тн Тухайн арга хэмжээг Нийслэлийн Захирагчийн ажлын албатай хамтран хэрэгжүүлсэн. Хавсралт : 1 файл Хүрсэн түвшин : Нийслэлийн хүн амын 2019-2020 оны өвөл, хаврын махны хангамжийг нэмэгдүүлэх, үнийг тогтвортой хадгалах зорилгоор арга хэмжээг хэрэгжүүлсэн.
12	4.2. Хүн амын эрүүл, аюулгүй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хангалтыг нэмэгдүүлэх.	1. Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх хувь			5	Улсын төсвөөс 160 сая төгрөг , НҮБ-ээс 113.5 сая төгрөг Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2020 онд улсын төсвөөс 160 сая төгрөг, НҮБ-аас 113.5 сая төгрөгийн үрийн дэмжлэг үзүүлж, төмс 18.6 мянган га -д тариалж 240.5 мянган тн, хүнсний ногоо 9.7 мянган га -д тариалж 113.5 мянган тн ургац хурааж, хүн амын хэрэгцээт төмсийг 149 хувь, хүнсний ногооны 44.6 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангав. Үүнийг өнгөрсөн оны ургацын дүнтэй төмс 49.7 мянган тонноор, хүнсний ногоо 18.9 мянган тонноор тус тус ахиу байна. Хүрсэн түвшин : Байцаа 83.1 хувь, шар лууван 148 хувь, шар манжин 178 хувь, хүрэн манжин 169.1 хувь, сонгино 47.2 хувь, саримс 35.2 хувь, өргөст хэмэх 93.3 хувь, лооль 9.1 хувь, тарвас 28.7 хувь, бусад навчит ногоо 1.8 хувийг дотоодын үйлдвэрлэлээр тус тус хангав.

13		2. Жимс, жимсгэнэ тариалах шинээр нэмэгдэх талбайн хэмжээ, га			8000	Улсын төсвийн 109 тэрбум, Азийн хөгжлийн банкны 15 мянган доллар, ЖДҮ-ийг хөгжүүлэх сан 1 тэрбум 458 сая төгрөг.	2020 оны Улсын төсвийн 99.0 сая төгрөгийн санхүүжилтээр тендер шалгаруулалт зохион байгуулан, Говь-алтай, Сүхбаатар аймагт тус бүр 3 га талбай бүхий жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг байгуулав. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн 15.0 мянган ам.долларын санхүүжилтийн хүрээнд ХААИС-ийн харьяа Борнуур дахь туршилт судалгааны төвд “Жимс жимсгэний сортуудын туршилт судалгаа хийх, жимс жимсгэний генфонд байгуулах төсөл хэрэгжүүлэв. Үүний үр дүнд Чацарганы байгалийн хэлбэр дээжүүдээр генфонд байгуулж, суулгац үржүүлэх ажлыг эхлүүлэв. Монголын жимс жимсгэний үндэсний холбоотой гэрээ байгуулан “Жимс жимсгэний суулгац үржүүлгийн газар байгуулах техникийн ерөнхий шаардлага” стандарт оловсруулж батлуулав. ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас жимс, жимсгэнэ хүнсний ногоо боловсруулах 9 аймгийн 14 аж ахуйн нэгжид 1 тэрбум 458 сая төгрөгийн зээл олгов. Булган аймагт Шинэ хөдөө төслийн хүрээнд жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2018-2020 онд 217,500 ширхэг Үхрийн нүд, чацарганы суулгацыг иргэд аж ахуй нэгжид олгож, тариалуулав. Хүрсэн түвшин : Жимс, жимсгэнийн талбайг 150 га-аар нэмэгдүүлсэн
14		3. Хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшин, хувиар			60	Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 145 дугаар тушаалаар хөнгөлөлт үзүүлсэн.	Хөдөө аж ахуйн дэмжих санд үлдэгдэлтэй байсан төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн зориулалттай мотоблок, 50-80 морины хүчтэй трактор, бууц ачигч, урамал хамгааллын бодис цацах машин, үрлүүр, сийрүүлүүр, лууван, манжин ухагч, хүнсний ногооны 1-3 га талбайг услах усалгааны ситем зэрэг иж бүрдэл 450 гаруй техникүүдийн үнийг 50 хувиар хөнгөлж тариаланчдад олгосон. Энэ нь хүнсний ногооны гар ажлыг хөнгөвчилж хөрс боловсруулах, хүнсний ногоог үрлэх, тарилтын дараа арчилгаа хийх, усалгаа хийх ажлыг 60 хувь хүртэл механикжуулсан. Хүрсэн түвшин : Хүнсний ногооны гар ажлыг хөнгөвчилж хөрс боловсруулах, хүнсний ногоог үрлэх, тарилтын дараа арчилгаа хийх, усалгаа хийх ажлыг 60 хувь хүртэл механикжуулсан.
15	4.3. Үр тарианы талбайн хөрсний үржил шимийг сайжруулж, ургацын хэмжээг нэмэгдүүлэх, Атрын IV аяныг эхлүүлэх.	1. Хураан авах үр тарианы хэмжээ, мянган.тонн			400	Улсын төсвийн 5.0 тэрбум, Аж ахуйн нэгж, байгууллагын 12,6 тэрбум, нийтдээ 17.6 тэрбум төгрөг	2020 оны Ургац хураалтын дүнгээр 428.9 мянган тонн үр тариа, үүнээс 408.1 мянган тонн улаанбуудай, 240.5 мянган тонн төмс, 113.5 мянган тонн хүнсний ногоо, 21.2 мянган тонн тосны ургамал, 169.4 мянган тонн тэжээлийн ургамал тус тус хураан авч, гурил үйлдвэрлэлд 238.6 мянган тонн буудай нийлүүлэгдээд байна. Энэ онд аж ахуйн нэгж, иргэд 356.4 мянган га-д чанар сайтай уринш боловсруулж бэлтгэсний 196.1 мянган га талбайг нь дэвшилтэт технологиор боловсруулсан бөгөөд дараа оны тариалалтад зориулан аж ахуйн нэгж, иргэд 42.2 мянган тонн үрийн нөөц бүрдүүлсэн байна. Ургацын хэмжээг нэмэгдүүлж чанарыг сайжруулах, тариаланчдад учрах санхүүгийн дарамтыг багасгах, тариалалт, уринш боловсруулалт, ургац хураалтын

						ажлыг технологийн хугацаанд чанартай зохион байгуулах зорилгоор 4.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 2.6 мянган тонн шатахуун, 11.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий 12.5 мянган тонн улаанбуудайн үр, 2.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий бордоо, ургамал хамгааллын бодисыг 30-50 хувийн урьдчилгаатайгаар давхардсан тоогоор 1100 гаруй иргэн, аж ахуйн нэгжид зээлээр олгож дэмжлэг үзүүлснээр хураан авсан ургацыг өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад үр тариа 4.1 мянган тонноор, тэжээлийн таримал 49.8 мянган тонноор тус тус ахиу байна. Монгол Улсын Ерөнхий Сайдын 2020.01.09-ний өдрийн 05 дугаар захирамжаар Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий Зөвлөлийг байгуулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2020.03.27-ны өдрийн А-118 дугаар тушаалаар "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г батлан орон нутагт хүргүүлж эхний жилийн хэрэгжилтийг зохион байгуулсан болно. "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний эхний жилийн биелэлтийг гаргаж танилцуулахаар ажиллаж байна. Хүрсэн түвшин : Хэрэгцээт улаанбуудайн 80 хувийг дотоодын ургацаас хангасан
16	2. Усалгаатай талбайн хэмжээ, мянган га			50 хүртэл	БНХАУ-ын хөнгөлттэй зээл 16 тэрбум 50 хувь хөнгөлөөд 8 тэрбум	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд олгож буй усалгааны тоног төхөөрөмж, хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмжийг олгох үнэ нөхцөлийг батлах тухай Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2020 оны А-145, А-136 дугаар тушаалаар усалгааны тоног төхөөрөмжийн үнийг 50 хувь хөнгөлж урьдчилгаа төлбөргүй жилийн 6 хувийн хүүтэй 6 жилийн хугацаатайгаар олгосон. Үүний үр дүнд зээлийн шалгуур хангасан үр тариа, тэжээлийн таримал тариалдаг эрхэлдэг 30 аж ахуйн нэгж, иргэнд 42 ширхэг бороожуулагчийг зээлээр олгож, суурилуулаад байна. Үүний үр дүнд Усалгаатай газар тариалангийн талбайг 3000 га талбайгаар нэмэгдүүлсэн. Мөн Азийн хөгжлийн банкны "Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслийг 2020 оноос эхлүүлж үүний үр дүнд усалгаатай тариалангийн талбайг 7.9 мянган га нэмэгдүүлэх боломж бүрдсэн. Хүрсэн түвшин : 3000 га-аар нэмэгдүүлсэн. 7.9 мянган га нэмэгдүүлэх боломж бүрдсэн.
17	3. Аяны бэлтгэлийг хангах ажлын явц, хувиар			100	Улсын төсвийн 5.8 тэрбум төгрөг	Монгол Улсын Ерөнхий Сайдын 2020.01.09-ний өдрийн 05 дугаар захирамжаар Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий Зөвлөлийг байгуулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2020.03.27-ны өдрийн А-118 дугаар тушаалаар "Атар-4 тариалангийн

						<p>тогтвортой хөгжлийн аян-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г батлан орон нутагт хүргүүлж эхний жилийн хэрэгжилтийг зохион байгуулсан болно. "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ы төлөвлөгөөнд 86 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 77.7 хувиар эхний жилийн хэрэгжилтийг хангаж ажилласан.</p> <p>Хавсралт : 2 файл</p> <p>Хүрсэн түвшин : Ургац хураалтын дүнгээр 428.9 мянган тонн үр тариа, үүнээс 408.1 мянган тонн улаанбуудай, 240.5 мянган тонн төмс, 113.5 мянган тонн хүнсний ногоо, 21.2 мянган тонн тосны ургамал, 169.4 мянган тонн тэжээлийн ургамал тус тус хураан авч, гурил үйлдвэрлэлд 238.6 мянган тонн буудай нийлүүлэгдээд байна. Үүнийг өнгөрсөн оны ургацт харьцуулахад үр тариа 4.1 мянган тонноор, төмс 49.7 мянган тонноор, хүнсний ногоо 18.9 мянган тонноор, тэжээлийн таримал 49.8 мянган тонн тус тус ахиу байна.</p>	
18	4.4. Жижиг, дунд үйлдвэр болон загвар хоршоодыг санхүү, зээлийн бодлогоор дэмжих.	1. Ажлын байрын тооны өсөлт, хувиар			20	22,902.1 сая төгрөг	<p>Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь 2020 онд эргэн төлөлтийн эх үүсвэрийн хүрээнд төсөл хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 1579 төслийн 238,4 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт хүлээн авч 249 аж ахуйн нэгжийг 22,1 тэрбум төгрөгөөр дэмжиж, 1497 шинэ ажлын байрыг бий болгов. Энэхүү шинэ ажлын байр нь 2019 онтой харьцуулахад 49,6 хувиар бага байгаа нь Улсын төсөвт ЖДҮХС-ийн эх үүсвэрийг тусгаагүй, Ковидын нөхцөл байдлын улмаас Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд, ХХААХҮ-ийн Сайдын “Зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах” талаар гаргасан 2020 оны А-83, А-373 дугаар тушаалын хэрэгжилтийн улмаас төлөвлөсөн эргэн төлөлтийн орлого буурсантай холбоотой юм.</p> <p>Загвар хоршоо байгуулах тухайд 2020 оны Улсын төсөвт хөрөнгө санхүүжилт тусгагдаагүйн улмаас хэрэгжээгүй.</p> <p>Хүрсэн түвшин : 9.7 хувь буюу 1497 шинэ ажлын байр</p>
19	4.5. Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орнуудад “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг	1. Экспортын боловсруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт, хувиар			2.0-оос доошгүй	7,3 сая	<p>- Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээ, брэнд бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, олон улсын стандартад нийцсэн бараа бүтээгдэхүүнийг экспортлох, шинэ зах зээлд гаргах, түншлэлийг бий болгох зорилгоор “Улаанбаатар түншлэл-2020” Олон улсын үзэсгэлэн худалдааг 2020 оны 09 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд 110 гаруй ААН оролцсон. - "Монгол экспорт экспо-2020" дотоодын үзэсгэлэн худалдааг 2020 оны 11 дүгээр сард Мишээл экспо төвд зохион байгуулав. Үзэсгэлэн худалдаанд ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрлэлийн салбарын 108 үйлдвэрлэгчид оролцож, 300 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн. Нийт давхардсан тоогоор 6000 гаруй хүн очиж сонирхон худалдан авалт хийсэн.</p> <p>- "Экспорт монгол 2020" Олон улсын цахим форум, сургалт, виртуал</p>

	зохион байгуулах.					<p>үзэсгэлэнг ГХЯ, ҮХГ, Экспорт ДУХТөв ТББ-тай хамтран 2020 оны 12 сард зохион байгуулсан. Цахим үзэсгэлэн худалдаанд хөнгөн, хүнсний салбарын нийт 43 ААН 200 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцсон бөгөөд 10 гаруй орноос давхардсан тоогоор 24000 гаруй удаагийн хандалт хийж, сайтад байршуулсан ААН-ийн материалуудаас 200 гаруй материалыг татаж авсан байна. Нийт арга хэмжээний хүрээнд https://www.expromongolia.org/ хаягаар АНУ, Япон, Австри, ХБНГУ, Франц, ОХУ, БНХАУ, Их Британи, Сингапур, Вьетнам, Болгар, Чех, Польш, БНСУ зэрэг 20 орчим улсын 360 гаруй, дотоодын 1600 гаруй оролцогч бүртгүүлэн оролцож, бусад олон нийтийн сүлжээ, цахим хуудсаар 6400 гаруй удаагийн хандалт хийсэн.</p> <p>-“Ковид-19” цар тахалтай холбоотой 2020 оны 2 сараас хойш бизнесийн үйл ажиллагаа хумигдаж хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ 60 хүртэл хувиар буурсан. Тухайлбал, арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс шир өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад экспорт 54 хувиар буурсан, ноос ноолуурын салбарын борлуулалт 60% буурсан, ажиллах хүчний 50% сул зогссон, 10%-ийг цомхтгосон.</p> <p>Хүрсэн түвшин : 3 арга хэмжээг зохион байгуулсан.</p>
20	4.6. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.	1. Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар		21 аймагт үйлдвэр байгуулах	-	<p>ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд Бүтээн байгуулалтын ажил 100 хувь хийгдэж шинээр бүрэн ашиглалтад орсон 47 үйлдвэр, бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа 23 үйлдвэр, хөтөлбөрийн 5.4-т “Хөтөлбөр хэрэгжих явцад улсын болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин зэргээс шалтгаалан үр ашиг, ач холбогдол бүхий шинээр байгуулсан үйлдвэрийг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйлдвэрийн тоонд тооцож болно” гэж заасны дагуу ЖДҮХС, ОНХС, гадны хөрөнгө оруулалтаар 11 үйлдвэр, нийт 81 үйлдвэр 2018-2020 онд байгуулагдсан байна. Тус 81 үйлдвэрийг задлан харуулбал: Нийслэлд 5, орон нутагт 76 үйлдвэр /2017 онд 2, 2018 онд 22, 2019 онд 48, 2020 онд 9,/ шинээр байгуулагдсан болон үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна.</p> <p>Хөтөлбөрийн үр дүнд: Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 12 хувьд хүрч, арьс, ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 41 хувь, ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 26 хувь, нийт 81 үйлдвэр байгуулагдаж 4100 орчим ажлын байр бий болсон байна.</p> <p>“Ковид-19” цар тахлаас шалтгаалан хөрөнгө оруулалт болон зээл тусламж хязгаарлагдмал болсон, мөн шинээр байгуулагдаж байгаа болон шинэчлэгдэж буй үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжүүдийг импортоор оруулж ирэхэд тодорхой хэмжээний хүндрэлүүд үүсч байсан тул 2020 онд шинээр үйлдвэрүүд байгуулах ажил төлөвлөсөн</p>

						хэмжээнд хүрээгүй. Хүрсэн түвшин : 81 үйлдвэр байгуулагдсан.
ГУРАВ. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО						
21	9.3. Биологийн олон янз байдлын тухай болон цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах.	1. Биологийн олон янз байдалд чухал ач холбогдол бүхий газруудад хамгааллын болон доройтлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо			2-оос доошгүй	Улсын төсөв: 60.0 Төсөл, хөтөлбөр 25.0 Нийт 85.0 -БОАЖЯ-тай хамтран хэрэгжүүлж буй "Монгол орны унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах" төсөл Ар, ГоА, За аймгийн 13 суманд хэрэгжиж, 70.0 мянган долларын санхүүжилтээр бэлчээрийг зохистой ашиглах 48 малчдын бүлэг байгуулж, бэлчээрийн менежментийн сургалт явуулж, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулан ашиглаж, зэрлэг амьтдын амьдрах газрыг малаас чөлөөлж,биологийн олон янз байдлыг хамгаалах ажлыг зохион байгуулав. Сумдын малчдын малын чанарыг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлж, малын тоог бэлчээрийн даацад тохируулах зорилгоор тус бүр 1 малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулж, тухайн орон нутагт үржүүлж буй батлагдсан үүлдэр, омгийн малын стандартын шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой үржлийн малыг өсгөн бойжуулж, малчдад нийлүүлэх, мал үржлийн ажил үйлчилгээ үзүүлэх, сүргийн эргэлтийг зөв төлөвлөж, орлогыг нэмэгдүүлнэ. Аймгууд 2020 онд 4.9 сая га доройтсон бэлчээрийг сэлгэн өнжөөж сайжруулав. -“Тариалангийн талбайн хөрсний үржил шим, чийгийг нэмэгдүүлэх экологжсон арга, туршлага нэвтрүүлэх” зөвлөх үйлчилгээний ажлыг УГТЭШХ-р гүйцэтгүүлэв. Хөрсний үржил шимийг сайжруулах ногоон бордуурт ашиглах 12 төрлийн таримал ургамлын харьцуулсан туршилт судалгааны ажлыг гүйцэтгэсний зэрэгцээ биологийн олон янз байдлыг хамгаалах, байгаль орчинд ээлтэй аргаар хөрсний чийг, агаар нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, хог ургамалтай тэмцэх технологийн зөвлөмж боловсруулсан. Төслийн туршилтын талбайд "Хөрсний үржил шим, чийгийг нэмэгдүүлэх ногоон бордуур сэдэвт" үзүүлэх 200 хүний сургалт зохион байгуулж хөрс хамгаалах, газрын доройтлыг экологжсон аргаар сэргээх, биологийн олон янз байдлыг хамгаалахын ач холбогдлын талаар танилцуулга хийсэн. Тариалангийн талбайн хөрсний үржил шим, элэгдэл эвдрэлийг хянах зорилтын хүрээнд тариалангийн хөрсний мониторингийн сүлжээ байгуулах, сүлжээний байршлын болон агрохимийн картограммын зураглалыг боловсруулан www.monsoil.mn цахим хуудсанд байршуулав. Хүрсэн түвшин : - Малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж 3 байгуулж, бэлчээрийг зохистой ашиглах 48 малчдын бүлэг байгуулж, 4.9 сая га доройтсон бэлчээрийг сэлгэн өнжөөж сайжруулав. -Хөрсний үржил шимийг хянах хамгаалах 1 төсөл, хөрсний үржил шимийн үзүүлэлт, биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр 1 төсөл нийт 2 төсөл хэрэгжүүлэв.